



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 8/258

Номгон

Эвдэрсэн газрын хяналтын тооллого
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд уул уурхайн болон хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон газрын хяналтын тооллогыг 2026 оны 05 дугаар сарын 01-ээс 05 дугаар сарын 15-ны өдрүүдийн хооронд зохион байгуулсугай.


2.Хяналтын тооллого зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хяналтын тооллого зохион байгуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, холбогдох тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын архивд хүлээлгэж өгөхийг Ажлын хэсгийн ахлагч (Э.Ганзориг)-т, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлж ажиллахыг Байгаль орчны газрын дарга (Б.Бат-Өлзий)-д тус тус үүрэг болгосугай.

4.Хяналтын тооллого зохион байгуулах ажлын хэсгийн гишүүдийн томилолтын зардлыг шийдвэрлэж ажиллахыг холбогдох сум, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.


ДАРГА



Э.ЭНХБАТ

628010691

Аймгийн Засаг даргын 2006 оны 3 дүгээр сарын
28-ны өдрийн 2858 дугаар захирамжийн
... дүгээр хавсралт



ЭВДЭРСЭН ГАЗРЫН ХЯНАЛТЫН ТООЛЛОГО ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Ганзориг

Засаг даргын Зөвлөх

Гишүүд:

Б.Бат-Өлзий

Байгаль орчны газрын дарга

Д.Алтангэрэл

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын дарга

Т.Цэвээндорж

Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд
хурандаа

Х.Сонинбаяр

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс,
орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Сумдын Засаг дарга, Байгаль орчны хяналтын Улсын байцаагч, Байгаль
хамгаалагч, Газрын даамал нар

Нарийн бичгийн дарга:

Б.Наранбаатар

Байгаль орчны газрын Ахлах мэргэжилтэн

оОо